


УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААЛТЫН ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улс нь Парламентын засаглалтай орон юм. Улсын Их Хурал (Парламент)-ын сонгуулийг 4 жил тутамд нэг удаа явуулж 76 гишүүн сонгогддог. Мөн орон нутгийн сонгуулийг 4 жил тутам явуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн хурлыг байгуулдаг юм.

УИХ-ын 2016 оны сонгуулийн санал хураалтад 1932.3 мянган хүн сонгуульд оролцох нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байна. Үүний 73.7 хувь нь буюу 1424.5 мянган хүн сонгуулийн санал хураалтад оролцжээ.

Зураг 1.1. УИХ-ын сонгуульд сонгогчдын оролцоо, мянган хүн, хувь, онуудаар



1992 онд зохион байгуулагдсан анхны УИХ-ын сонгуульд сонгогчдын оролцоо 95.6 хувь байсан бөгөөд 2012 оны сонгууль хүртэл аажмаар буурч 67.3 хувьд хүрч байв.

Хүснэгт 1.1. Сонгогчдын оролцоо, хувь, сонгосон зарим улс орноор

Улс	Он	Сонгуулийн төрөл	Сонгогчдын оролцооны хувь (%)
Австрали	2013	Парламент	93.23*
Дани	2015	Парламент	85.89
Швед	2014	Парламент	85.81
Франц	2012	Ерөнхийлөгч	80.35
Норвеги	2013	Парламент	78.23
Итали	2013	Парламент	75.19
Голланд	2012	Парламент	74.56
Монгол	2016	Парламент	73.7
Герман	2013	Парламент	71.55
Их Британи	2015	Парламент	66.12
Канад	2011	Парламент	61.41
АНУ	2014	Парламент	42.5
	2016	Ерөнхийлөгч	54.5
Япон	2014	Парламент	52.66

УИХ-ын 2016 оны сонгуулийн хувьд иргэдийн сонгуулийн оролцоо өмнөх сонгуулиудтай харьцуулахад харьцангуй бага боловч өмнөх 2012 оны сонгуулийнхаас 6.4 пунктээр сонгуулийн идэвх нэмэгдсэн байна. /Зураг 1/.


Монгол улсын сонгогчдын оролцоо Герман, Их Британи, Канад, АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй улс орнуудынхаас өндөр байгаа бөгөөд Дани, Швед, Франц, Норвеги, Итали, Голланд гэсэн улсуудынхаас бага байна.

* - сонгуульд заавал оролцох ёстой.

Монгол улсын сонгогчдын сонгуулийн идэвх нь нас ахих тусам нэмэгдэж байгаа доорх зургаас харагдаж байна. 2016 оны сонгуулийн жилд ойролцоогоор 192 мянган залуучууд 18-21 насны бүлэгт дэвшиж сонгууль өгөх эрхтэй болсон бөгөөд 18-25 насны залуучуудын 46.7 хувийг эзэлж байна.

18-25 насны залуучуудын сонгуулийн идэвх хамгийн муу байна. Энэ насны бүлгийн 2 хүн тутмын нэг буюу ойролцоогоор 50 хувь нь сонгуульд оролцоогүй байна. Энэ нь шинээр сонгууль өгөх эрхтэй болсон залуучуудын хувийн жингээс ч өндөр үзүүлэлт юм.

Зураг 1.2. УИХ-ын сонгуульд сонгогчдын оролцоо, насны бүлгээр, мян хүн, хувь, 2016 он




Насны бүлэг ахих тусам сонгуулийн идэвх нэмэгдэж байгаа бөгөөд 60-аас дээш насныхны хувьд 100 хүн тутмын 97 нь санал хураалтад оролцжээ.


Хүйсийн хувьд эмэгтэйчүүдийн 76.6 хувь, эрэгтэйчүүдийн 70.6 хувь сонгуульд саналаа өгсөн байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү хариуцлагатай, илүү идэвхитэй байгааг илтгэж байна.

УИХ-ын 2016 оны сонгуулийн дүнгээс харахад санал хураалтын оргил цаг нь 13 цаг байна. Энэ цагт 152.8 мянган хүн саналаа өгч, 11-15 цагийн хооронд нийт санал өгсөн сонгогчдын 47.3 хувь буюу 673.6 мян хүн санал хураалтад оролцсон байна /Зураг 2/.

Зураг 1.3. УИХ-ЫН СОНГУУЛЬД САНАЛ ӨГСӨН ИРГЭД, цагаар



Зураг 1.4. УИХ-ЫН СОНГУУЛЬД САНАЛ ӨГСӨН ИРГЭД, цаг, насны бүлгээр




Санал өгсөн хүмүүсийн тархалтаас харахад хүмүүсийн нас ахих тусам өглөө, үдээс өмнө санал хураалтад оролцсон тохиолдлын тоо нэмэгдэж байна.

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ /Сонгинохайрхан дүүрэг/

Аймгуудтай харьцуулахад улсын хэмжээнд сонгуулийн хамгийн идэвх муутай 3 дүүргийн нэг нь Сонгинохайрхан дүүрэг (45.7%) байсан.

Зураг 2.1. Орон нутгийн сонгуульд санал өгөгчдийн хувийн жин, 2016




Орон нутгийн сонгуульд сонгогчдын нас ахих тусам сонгуулийн идэвх нэмэгдэж байгаа зүй тогтол хадгалагдаж байна. Сонгуулийн жилд ойролцоогоор 16.9 мянган залуучууд 18-21 насны бүлэгт дэвшиж сонгууль өгөх эрхтэй болсон нь 18-25 насны залуучуудын 43.6 хувьтай тэнцэж байна.

18-25 насны залуучуудын сонгуулийн идэвх хамгийн мүү 32.6 хувьтай байна. 26-40 насны хүмүүсийн 35.9 хувь, 41-55 насны хүмүүсийн 49.0 хувь нь сонгуулийн санал хураалтад оролцсон байна. Сонгуулийн идэвх хамгийн өндөр 56, түүнээс дээш насны сонгогчдын идэвх 66.0 хувь байгаа нь улсын дунджаас 31 пунктээр бага байна.


Хүйсийн хувьд эмэгтэйчүүдийн 49.4 хувь, эрэгтэйчүүдийн 41.7 хувь сонгуульд саналаа өгсөн байна. Энд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү идэвхитэй байгааг боловч улсын дунджаас даруй 27.0 пунктээр бага байна.

Зураг 2.2 Орон нутгийн сонгуулийн сонгогчдын оролцоо, насны бүлгээр, мян хүн, хувь, 2016 он




Сонгинохайрхан дүүргийн орон нутгийн сонгуульд оролцогчдын 51.4 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

Зураг 2.2. Орон нутгийн сонгуульд санал өгөгчдийн тоо, боловсролын түвшнээр



Сонгинохайрхан дүүргийн бүрэн дунд боловсролтой сонгогчдын 85.0 хувийг 26, түүнээс дээш насныхан эзэлж байна.

Зураг 2.3. Орон нутгийн сонгуульд оролцсон бүрэн дунд боловсролтой санал өгөгчдийн тоо, тоо, хувь, насны бүлгээр




Зураг 2.4. Орон нутгийн сонгуульд оролцсон бүрэн дунд боловсролтой санал өгөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээр




Дээрх иргэдийн 41.1 хувь нь цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж байгаа бол 42.1 хувийнх нь хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр нь тодорхойгүй байна.

Дээрх иргэдийн 21.6 хувь орлогогүй, 13.2 хувь тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговрын орлоготой, 21.6 хувь бусад орлого гэсэн орлогын эх үүсвэртэй байна.

Зураг 2.5. Орон нутгийн сонгуульд оролцсон бүрэн дунд боловсролтой санал өгөгчдийн тоо, орлогын хэлбэрээр




Зураг 2.6. Орон нутгийн сонгуульд оролцсон санал өгөгчдийн тоо, санал өгсөн цагаар



Сонгуульд оролцогчдын давтамж хамгийн өндөр 11-12 болон 18-19 цагийн хооронд байсан байна. Сонгинохайрхан дүүргийн сонгогчдын тэн хагас нь 14 цагаас өмнө, үлдсэн хагас нь 14 цагаас хойш саналаа өгсөн байна.

Зураг 2.7. Орон нутгийн сонгуульд оролцсон санал өгөгчдийн тоо, нэг насны бүлгээр



Сонгуульд оролцогчдын давтамж хамгийн өндөр 26-32 насныхан байсан байна.

Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн насны хүн амын тэн хагас нь 42-доош насны, үлдсэн хагас нь 42-с дээш насны хүмүүс байна.

Сонгуулийн идэвх сул кластер болох нийслэлийн дүүргүүд, хүн амын чухал бүлэг болох залуучуудын хувьд сонгуульд оролцоогүй шалтгааныг нарийвчлан судлах эрэлт хэрэгцээ байгаа нь сонгуулийн үр дүнгээс харагдаж байна.